

## “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НЫ ЗАРИМ ҮГ ХЭЛЛЭГИЙГ ЭТНОЛИНГВИСТИКИЙН ҮҮДНЭЭС ШИНЖЛЭХ НЬ

**Ч.БАТТУЛГА**

МУИС, ШУС, Монгол хэлний тэнхим, e-mail: ch\_tusgalt@yahoo.com

**ТҮЛХҮҮР ҮГ:** Монголын нууц товчоо, хэв хууль, зан үйл, уламжлалт анагаах ухаан, хоол хүнс,

**ТОВЧ АГУУЛГА:** МНТ-ны 53-р зүйл: *haci abu* “хачи (өшөө) ав”, 195-р зүйл: “*Alalduqu üdür haran-i miqa idet tede gürülcegiü üdür gü'ün-i miqa günesület tede* “Алалдах өдөр араны мах иднэ, Хүрэлцэх өдөр хүний мах хүнслэнэ, тэд”, 151, 152, 177-р зүйл: *tete'en-ü cisun qanaju* “тэмээний цус ханаж идэх” гэсэн гурван хэллэгийг тухайн нийгмийн үүрэг, хэв хууль, уламжлалт анагаах ухаан, хоол хүнсний зүйлтэй холбон тайлбарлалаа. Эдгээр хэллэгт энэ мэт гүн гүнзгий утга учир агуулагдаж буй тул, цаашид МНТ-ны үг хэллэгийн утга гарлыг зөвхөн тайлбарлаад зогсохгүй монгол угсаатны амьдрал ахуй, ёс заншил, зан үйлтэй холбон нарийвлан судлан шинжлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол туургатны түүх, утга соёл, үгийн урлагийн гайхамшигт дурсгал “Монголын Нууц Товчоо”-ны зарим үг хэллэгийн гарал үүсэл, утга учрыг нийгэм, соёл, сэтгэц, угсаа хэл шинжлэлийн заагт нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага байсаар байна. Уул өгүүлэлд бид “МНТ” дахь гурван ч зан үйлийн учир холбогдлыг тодорхой баримтад тулгуурлан өгүүлээ. Чингэхгүй аваас, нүүдэлчин монголчуудын нарийн нандин ёс уламжлал, ахуй амьдралын талаар дутуу дулимаг мэдлэгтэй, өнгөц нимгэн ойлголттой хүмүүс буруу зөрүүгээр мушгин гуйвуулах хандлага газар авах шинжтэй юм.

### 1. **haci (хачи) буюу Тэмүжин Амбагай хааны хачийг хариулсан учирт**

“МНТ”-ны 53-р зүйлд: *Ambaqai-qahan besütei gü'ün balaqaci e[l]cin-i'er ügülejü ilērün qabul-qahan-nu dolo'an kö'üd-ün dumdatu qutula-da ügülerün harban kö'üd dotora qada'an-taisi-da ügüle ke'en ügülejü ilērün qamiq-un qahan ulus-un ejen bol[u]ju öki-ben ö'esün hüdeküi-ben nama-'ar kesetkün tatar irgen-e bariqda'a bi tabun quru' ud-iyān kimul*

*tamutala harban quru' ud-iyān ha'uttala haci minu aburan sori[t]qun ke'ejü ilējü'ü* (Igor de Rachewiltz 1972: 22) хэмээх өгүүлэмж дэх “хачи авах”(haci abu) гэсэн хэллэгийн талаар өгүүлэхийн урьдаар уг түүхэн явдлыг тодруулав.

“Хабул хаан Мэргэд, Хэрэйд, Найман зэрэг аймагтай зузаан холбоо тогтоож, Алтан улсын гар хөл болсон Татартай тэмцэл хийж, Зүрчидийн Алтан улсаас Монголын эсрэг явуулж агсан хөнөөлт бодлогоос улс орноо, удам угсаагаа, ард олноо сэргийлэн хамгаалах ажиллагааг тууштай хийж байжээ (Далай 1996:41)

Хамаг Монгол улс Татаартай эвдрэлцсэн шалтгааныг “Хабул хааны хатны дүү Сайн тэгин хүндээр өвчлөхөд Татар аймгаас бөө залжээ. Бөөгийн нэр нэр цуутай Чаргил нүдэн гэдэг байжээ. Тэрбээр бөө буусан боловч Сайн тэгин нас баржээ. Гэвч бөөд өргөл барьц бариад буцаажээ. Гэтэл Сайн тэгиний ах дүү ака ба ини хоёр бөөгийн хойноос очиж хөнөөжээ. Хабул хааны хөвүүд нь ингээд Сайн тэгиний улмаас татарчуудтай байлдаж

эхэлжээ (Рашид-Ад-Дин 2002: 191) гэж үздэг боловч түүхч, эрдэмтэн Ч.Далай зэрэг эрдэмтэд энэ нь зөвхөн шалтаг, харин гол шалтгаан нь улс төр эдийн засгийн шинжтэй байсан гэжээ.

Татарууд Хабул хааны ахмад хүү Охин бархагийг гэнэдүүлэн барьж аваад Алтан улсад хүргүүлснийг модон илжгэнд хадаж цаазалжээ. Амбагай хаан Татарчуудтай хэл амаа ололцох гэж хэдий их хүч чармайлт гаргасан ч бүтэлгүй болсоор, эцэст нь тэдэнд охиноо өгч, өөрөө охиноо хүргэж очоод баригдан, мөн л модон илжигт хадуулан нас эцэслэжээ.

Хотула хаан, Хадаан тайш нар Татартай харьцангуй их цэргийн хүчээр 13 удаа байлдсан боловч ялалт олоогүй мэтээр сурвалжид тэмдэглэсэн. Татаарын ар талд Алтан улс байсан болохоор тэдэнд зэр зэвсэг, хоол хүнсний дутагдал гэж юм байсангүй. (Ийнхүү) ... Хамаг Монгол Татарын хооронд үргэлжилсэн 70 жилийн тэмцэл тулалдаан 1202 онд Чингис хаан Татарыг бүрмөсөн байлдан дагуулснаар дуусгавар болсон билээ (Далай 1996: 52). Ингэж Тэмүжин Чингис хаан өвөг дээдсийнхээ хачийг авч, ачийг хариулав.

Монголчуудын “хачи” авах буюу өшөө хонзон авах ёсны талаар эрдэмтэн Д.Дашцэдэн “XII зууны үед монгол аймгуудын дотор өшөө хонзон авах нь нилээд дэлгэрэнгүй үзэгдэл байжээ. Энэ нь эхний үед нэг аймаг нь, нөгөө аймгаас заавал өшөө авч хэн нэгнийг алах хүйс тэмтрэх, эсхүл хорлох, алах, харин хожуу буюу XII зууны дунд үеэс гол төлөв дайн байлдаан хийж өс хонзонгоо тайлах зэргээр илэрч байжээ. Нууц товчоонд дурдсанчлан өшөө хонзон авах нь монголын хэв хуулийн нэгэн төрөл болон заншлын эрхийн хэм хэмжээгээр зохицуулагдаж тэр нь “нүдийг нүдээр”, “чихийг чихээр” гэсэн эртний цусан өшөө үргэлжилж байсан гэж үзэх үндэстэй байна. Нууц товчооны 58, 67, 77, 78, 102, 105, 113, 133, 136-р зүйлүүдэд өшөө авах тухай заасан байна” (Дашцэдэн 1980: 40) гэсэн бол П. Рачневский “Өшөө хорсол нь Тэнгэрийн ивээсэн ёс суртахуун үүрэг байсан агаад Чингис өшөө авах эрхэндээ

итгэлтэй байсан билээ” (Рачневский 2006: 105) гэжээ.

Эндээс үзэхэд, Монголчуудын өшлийг өшиж, хяслыг хясаж “хачи” авах ёс нь тухайн цаг үе дор хэв хууль төдийгүй нийгмийн үүрэг байжээ гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-д “Чингис хаан Алтан ханы эсрэг дайтахаар Умард Хятад уруу довтлохдоо тэрбээр тэнгэрт сөгдөж аврал ивээл эрин өгүүлсэн нь: Хятадын эзэнтэнгүүд нь миний төрөл ахас дээдэс Амбагай хан, Охин бархаг ба Хадаан тайш нарыг хэрцгийгээр хөнөөсөн тул би тэднийхээ өшөөг авахаар явна. Аугаа их мөнх тэнгэр минь та аврал ивээлээ хайрлана уу хэмээн мэхийж байна” гэж даатгаад мориндоо мордон явлаа. Болгоогтун” (Рашид-Ад-Дин 2002: 192) гэсэн, Тэмүжин, Хасар нар Бэгтэрийг хороох үед Бэгтэрийн хэлсэн “Тайчууд ах дүү нарын хөнөөлийг баран ядан, хэрхэн өшөөгөө авна хэмээж бүхүйд намайг яахин нүдний сормуус, амны хахаас болгоно та нар (МНТ 2009: 32), Бэгтэрийг хороосны дараа Өгэлүн үжиний хэлсэн “Тайчууд ах дүү нарын гашуун хөнөөлийг баран ядаж бүхүйд, хариугаа хэн, хэрхэн авна хэмээж байхад, юунд ийм юм хийцгээнэ та нар (МНТ 2009: 32) гэсэн үг бас чухал нотолгоо юм.

Нөгөөтэйгүүр, өшлийг өшиж, хяслыг хясаж “хачи” авах ёс болон “МНТ”-ны 154-р зүйлд: “Татаарыг мохотгон дагуулин барж, улс иргэнийг нь хэрхэх вэ хэмээн, Чингис хаан ургаараа нэгэн гэрт орж, зетэлдэв.

Эрт өдрөөс Татаар иргэн  
Өвгөд эцгийг барсан бүлгээ  
Өвгөд эцгийн  
Өшил өшиж  
Хясал хясаж  
Цүүнд үлиж чацуулж  
Хядаж алж өгье  
Үлитгэл хядъя  
Үлдэгсдийг боолчилъё  
Зүгт зүгт хуваалдъя”

хэмээн зөвлөн тогтов (МНТ 2009: 80) гэсэн зэргээс улбаалан эзэн Чингис хааныг ихэд харгис хэрцгий хүн байсан гэх хандлага бий. Ингэж үзэхийн урьд нэрт монголч эрдэмтэн

Б.Я.Владимирцовын “Чингис нь цаг үеийнхээ бүтээл, ард түмнийхээ хүү байсан болохоор түүнийг өөр эрин үе, дэлхийн бөмбөрцгийн аль нэг өөр орчинд шилжүүлэлгүй, тухайн эрин үе, тухайн орчиндоо амьдарч байгаагаар нь авч үзэх ёстой юм” (Владимирцов 2001: 100) гэсэн алдарт үгийг санаж сэрэх ёстой юм.

Харин дээрх хэллэгийн “хачи”(haci, haciban, haci-yian, бас hacilaqun, haciran, hacitu) гэдэг үг “МНТ”-д хоёр ондоо утгаар хэрэглэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, уул үг “МНТ”-нд 14 удаа тохиолдоход 53, 77, 78, 102, 105, 214 –р зүйлд хачи - өшөө, 75, 163, 177, 214-р зүйлд ач-тус гэсэн утгаар оржээ. Ач (aci) гэсэн хэлбэрээр тохиолдохгүй байна.

Үүнийг академич Д.Цэрэнсодном “Хачи «өшөө хонзон» гэсэн утгатай «ачи» гэдэг үг бас «ач» хариулах гэсэн өөр үгтэй ижлээр «МНТ»-д яагаад бичигдсэн бэ? Бидний санахад энэ үгийн эхний Х гийгүүлэгч XIV зууны галиглагчдын хэл аялгуунд h болж сонстож улмаар алга болох хандлагатай тэмдэглэгдсэн учир «хачи» (өшөө), ачи (хариулах ёстой тус) гэсэн хоёр шал өөр үг ижил бичлэгтэй болсон бололтой. Иймд энэ «өшөө» гэсэн утгатай энэ «hачи» гэсэн үг. «МНТ»-ны хуудам монгол эхэд «хачи» гэж бичигдсэн байснаар төсөөлөн бодож, бид «хачи» гэж сэргээн сийрүүлсэнээ зөв гэж бодно” (Цэрэнсодном 1990: 247) хэмээн «хачи» гэж сэргээн сийрүүлсэн нь зөв болов уу. Харин эрдэмтэн М.Базаррагчаа “hачи” /ач-өшил/ нь “ка-чи-р” /хачир, нэмэр, дараас/, качин /хачин/ -аас тус тус үүссэн. I. “а-чи” /ач-өшөө/, а-та-га /атаа/, а-ча /ач/, II. а-чи /ач тус нэмэр/ гэсэн сөрөг утга (знантиосемия) буюу үгийн утга эсрэгцэн салаалжээ. Эдгээр нь “алив юманд нэг юм нэмэх” нь эсвэл “ач тус болдог” нэг бол “гай түй буюу дараас болдог”-оос үүджээ (Базаррагчаа 1999: 382) хэмээн үгийн утга эсрэгцэн салаалах зүй тогтолтой холбон тайлбарласан.

Бид “МНТ”-ны хэлний баримтад тулгуурлан “хачи” гэдэг үг нь хоёр өөр утга зааж буй өөр үг биш, угаас “хариу эрсэн тус”, “хариу хүссэн өшил”-ийг илэрхийлдэг, орчин цагийн монгол хэлний “хариу” гэсэн үгтэй

ойролцоо салаалсан утгатай үг байсан гэж үзлээ. “МНТ”-ны 177-р зүйлд “tusa-yin chinu haci uguq-un uguq-a cinu haci qari ’ulqu-yi” гэснээс тодорхой харж болно.

## 2. **Alalduqu údúr haran-i miqa idet tede gürülcegü údúr gü’ün-i miqa gūnesület tede** буюу хүний мах иддэг гэхийн учирт

“МНТ”-ны 195-р зүйлд: Найманы цэрэгтэй тэнд цуг морилж явсан Жамухаас Таян хаан асуужээ. “Тэд юун хүмүүс олон хонийг чоно үлдэж, хотонд ортол нь хөөж ирэх мэт эд юун хүмүүс тийн үлдэн айсуу” хэмээн асуув: Жамуха өгүүлэрүүн: “Тэмүүжин анд минь дөрвөн нохдыг хүний махаар тэжээж, гинжилж уяж байх бүлгээ”... “Алалдах өдөр араны мах иднэ тэд, хүрэлцэх өдөр хүний мах хүнслэнэ тэд...” (МНТ 2009: 119) гэсэн хэллэг буй.

Мөн 1245-1247 оны үед Монгол газраар аялсан Жиованни дель Плано Карпинийн тэмдэглэлд “Зажилж залгиж болох бүх л юм тухайлбал, чоно, нохой, үнэг, адуу, аргагүйдвэл хүний мах ч тэдний хоол болно. Сая төрсөн унаганы эхсийг ч хүртэл иднэ. Эднийг бас хулгана идэж байхыг ч үзсэн” (Плано Карпини 1988: 23), Хэртфордшир мужийн гэгээн албат хот дахь Бенедиктийн сүмийн санваартан Матью Парис 1240 онд бичсэн тэмдэглэлд “Адгуусан төрөлт тэднийг хүн гэхээс нохой амьтад гэвэл зохино. Цус ууж улангассан, хүний хүүрийг нохой мэт урж тасчин иддэг. Малынхаа цусыг уудаг бөгөөд ихэд таашаадаг (Жак Уэтэрфорд 2012: 141), 1240-1241 оны үед Монголчуудыг өөрийнхээ нүдээр харсан Унгарын эрдэмтэн, Сплитийн архидиакон “Хүмүүс ч гэсэн хоол хүнсэндээ тэгтлээ их анхаарахгүй бөгөөд хатуу ширүүн хүмүүжлээрээ л амьд явдаг мэт байх бөгөөд талх тариа үл хэрэглэнэ. Дан мах идэж, гүүний сүү айраг, бас цус ууна (Эрэнжен хара-Даван 2003: 201) гэсэн зэргээс улбаалан өрнө дахинд бидний өвөг дээдэс, ялангуяа эзэн Чингис хааныг харгис, хэрцгий, дээрэмчин тонуулчин, зэрлэг бүдүүлэг бүр канибалист маягаар эндүү ташаа ойлгох үзэл гарчээ.

Эрдэмтэн Л.Чулуунбаатар “XIII зууны үед Монголчууд хүний мах идэж байв уу” гэсэн өгүүлэлдээ Англи улсын Кембрижийн Их сургуулийн номын санд хадгалагддаг XIV зууны үеийн номын, нэр үл мэдэгдэх зураачийн зурсан хүний мах гал дээр шараад идэж байгаа хоёр монгол гэх хүний зургийг хэвлүүлж “...илбэчний мэт шовгор оройтой малгайг эс тооцвол монгол хүн гэж хэлэхэд бэрхтэй юм. Юунд ч торохгүй дорно зүгээс довтлон ирж байгаа монголчуудаас айсан айдас энэ зургийг бүтээсэн байж болох юм. Учир нь довтлон ирж буй хүмүүс бол ингэж хүний мах иддэг бөгөөд олзлогдвол хэн хүнгүй ингэж идэгдэх тул үхэн үхтлээ тэмцэх хэрэгтэй хэмээн ард түмнээ уриалахад ашиглаж байсан байж болох талтай. Нөгөө талаар дэлхийд түгээмэл байдаг нэн ялангуяа өрнөдөд түгээмэл байдаг канибализмийн үзлийг монголчуудад байж л таараа гэж таамгаар нялзаан бодсоны илрэл байж” гээд “МНТ”-ны 195-р зүйлд тохиолдох дээрх хэллэг нь зохиогчийн зүгээс “... есөн өрлөг жанжин болон Хасар баатрын хүч чадлыг аугаа их болгож үзүүлэхийн тулд ийнхүү үлгэр домгийн хэтрүүлгийн дүрслэлийг ашиглан хэлсэн” (Чулуунбаатар 2008: 247) гэсэн нь үнэнд нийцнэ.

Нэн ялангуяа, эртнээс нааш ан гөрөөгөөр элбэг баян, өргөн уудам нутагтай, гэртээ найман мянган жилийн өмнөөс адгуусан амьтдыг гэршүүлэн гаршуулж ирсэн анчин гөрөөчин, малчин нүүдэлчин Монголчуудыг “канибализм” хэмээх гаж үзэгдэлтэй холбох нь ямар ч үндэсгүй юм.

Гэвч, овоо босгоогүй бол шаазгай юун дээр суух вэ? гэдэг монгол ардын үг буй. Оргүй хоосноос ийм зүйл үүсэхгүй. Тиймээс бид, МНТ-ны 195-р зүйлд буй “*Alalduqu üdür haran-i miqa idet tede gürülcegü üdür gü’ün-i miqa gūnesūlet tede* Алалдах өдөр араны мах иднэ, Хүрэлцэх өдөр хүний мах хүнслэнэ, тэд” гэсэн хэллэгийн цаад учрыг Монголчуудын дайн тулаантай цаг үед шувууны махыг урьдчилан сэргийлэх эмчилгээний

зориулалтаар хэрэглэдэг байсан монгол анагаах ухааны уламжлалтай холбон үзлээ.

Шувуу судлаач Н.Цэвээнмядаг гуай “Чингис хаан аян дайн хийхдээ хойлгийн мах идсэн цэргүүдийг эхний эгнээнд явуулдаг байсан гэдэг. Яагаад гэхлээр хойлгийн мах идсэн хүний шарх маш хурдан эдгэдэг сайн талтай” (Цэвээнмядаг 2005) гэснээс хэдий мал адгуулахын зэрэгцээ, том ан амьтан элбэг байсаар атал шувууны махыг хэрэглэдэг байсны учрыг мэдэж болно.

Энэ уламжлал одоо хүртэл хадгалагдсаар байна. Мэс засалд орохын өмнө хойлгийн мах идвэл шарх хурдан эдгэдэг. Гэмтэж шархадсан хүн хойлгийн махыг чанаж шөлийг уухаас гадна хатсан махыг нунтаглаад шархан дээрээ цацаж эмчилнэ. Хойлгийн махыг борцлон хатааж эмчилгээнд хэрэглэнэ. Орчин үеийн анагаах ухаанд хойлогны мах үл орлогдох амин хүчлээр маш баялаг болох нь тогтоогдсон. Тухайлбал, Хойлгийн маханд аливаа шархны эдгэрэлтэд нөлөөлдөг сульфгидрилийн бүлэг агуулсан амин хүчил цистин 4.28% -тай байдаг бол тахианы маханд 0.7 %. (Зориг, Ямаахай 1980: 34) байдаг ажээ.

Нөгөө нэг байж болох гаргалгаа бол хойлгийн мах идсэн хүний шарх маш хурдан эдгэдэг тул Монголчууд дайн тулааны үед шархдаж гэмтсэн олон хүний амь биеийг аврахын тулд хойлгийн мах идсэн хүний их мах<sup>1</sup>ыг “хэрэглэж” байсан байж болзошгүй юм. Манай зарим нутагт эцэг эх нь хүүгээ цэрэгт явахад нь “Хойлгийн мах идсэнээ нуугаарай”, “Хүний ганц хүү бол *Хүний ганц хүү* гэдгээ хүнд битгий хэлээрэй” гэхчилэн захидаг байсныг сайтар ухвал дээрх зүйлтэй холбогдож болохоор байна.

Их махыг уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг байсан одоо ч “хэрэглэдэг” тухай мэр сэр баримт мэдээлэл, үзсэн цуглуулснаа дараагийн удаа тусгайлан өгүүлнэ.

3. **teme'en-ú cisun qanaju** буюу мал амьтны цус уудаг тухай товч

<sup>1</sup> Хүний махыг ийнхүү эерүүлэн хэлдэг

“МНТ”-ны 151, 152, 177-р зүйлийн “Тоорил хаан Уйгар, Тангудын газраар бядан явахдаа ядарч, таван ямаа шөрөглөн сааж, тэмээний цус ханаж идэж, ганц сохор халиун морьтой ядарч явж” гэсэн өгүүлбэрт “тэмээний цус ханаж идэх” (*teme'en-ü cisun qanaju*) гэсэн хэллэг, бас Марко Пологийн аяны тэмдэглэлд “Тулгам бэрх үед (тэд) гал түлж хоол, унд хийж идэлгүйгээр, өөрсдийн морьдынхоо судсыг ханаж, цусаар нь ундаалан өл залгасаар, арван хоног ч буулгүйгээр шавдан довтолгдгийг та нарт очье” (Марко Поло 1987) хэмээнээс үүдээд монголчууд морь малынхаа судсыг ханаж цусыг нь түүхийгээр уудаг гэх болжээ.

Халимагийн эрдэмтэн Эрэнжен Хара-Даван “Хоол хүнсний нь нөөц дууссан үед монголчууд мориныхоо судсыг ханаж цусыг нь хэсэг уугаад дараа нь хүлгийнхээ шархыг боож тогтоодог байлаа. Хүний гэдэс цадахад хагас литр цус л хангалттай байдаг бол морины хувьд, ялангуяа хөтөлгөө морины хувьд төдий хэрийн цус огт нөлөөлөхгүйгээс гадна маш богино хугацаанд нөхөгддөг байна. 1806 онд Кавказыг эзлэх үед халимагчууд ийм аргаар хүнсээ бэлтгэж байв. Монгол цэргийн ачаа тээшинд хэрэглэгддэг байсан тэмээнийхээ суганд тэд гамбир хэлбэртэй гурил хавчуулан болгож иддэг байв” (Эрэнжен Хара-Даван, 2003) гэжээ.

Угсаатан судлаач эрдэмтэн Н.Л.Жуковская (2010) “Малынхаа хөлийг боон газарт унагаад хүзүүнийх нь орчимд байдаг венийн судсыг зүсээд цусыг нь ямар нэг саванд тосч аваад эсвэл заримдаа шууд зүссэн хэсгээсээ сорж уудаг байна. Малдаа хор хүргэхгүйгээр нэг удаадаа 330 гр цус авахад энэ нь нэг хоногийн хүнсэнд хангалттай хүрнэ (Tannahill R. 1973: 130). Аяллын хүнс болсон цус нь тусгай тээврийн хэрэгсэл шаардлагагүй, тусгайлан бэлтгэх шаардлагагүй маш амар бүтээгдэхүүн юм. “Амьд цус”-ыг халаагаад дотор нь цөцгийн тос, бяслаг зэргийг хийгээд ороож идэж

болно, Төвдүүд голдуу ингэж хийдэг (Ekvall R. 1963) гэх зэргээр бичсэн байдаг. Үүнээс үзэхэд монголчууд дайн тулааны хүнд хэцүү цаг үед малынхаа цусаар өл хоол залгаж байсан байж болохыг үгүйсгэшгүй юм.

Харин эрдэмтэн З.Лонжид “МНТ”-ны дээрх хэллэгийг “Монголын цэрэг дайчид XIII зуунаас аргагүй тохиолдолд агтныхаа цусаар өл залгуулж байсан нь XIX зууны эх хүртэл уламжлагдсаар байжээ. Гэтэл сарлагийн цус ханаж хоол хүнс орлуулах заншил Монголын зарим нутагт 1900-гаад оны эхэн үед ч байсан мэдээ бий. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Цээл сумын уугуул Даржаагийн Чогдов гэлэн гэгч 1905-1908 онд номын багшдаа бараа болон Хөх нуур Цайдам орчим бүтэн дөрвөн жил сууж байхдаа тэндэхийн дээд монгол бүсгүйчүүд зочин ирэхэд шанага хатгуурын хутга хоёроо авч зэлэн дээрээ очоод сарлагуудаасаа аль нэгийг нь тушиж байгаад дөрөөлөх судсыг нь ханаж цусыг нь шанагандаа тосч аваад түүнийгээ цогон дээр хуурч, давс, зонхо гэдэг ногоогоор амтлан дайлдаг байсан гэж ярьдаг байлаа” (Лонжид, 2012) хэмээн монгол хоол хүнсний зүйлд хамруулж үзсэн нь сонирхолтой юм.

Эрдэмтэн Роберт Эквэлийн “Амьд цус”-ыг халаагаад дотор нь цөцгийн тос, бяслаг зэргийг хийгээд ороож идэж болно” гэсэн нь үнэндээ монгол үндэстний хоол хярамцаг<sup>2</sup>ийг хэлсэн хэрэг гэж бодож байна. Одоо ч Архангай аймгийн Чулуут зэрэг өндөр уулын бүсийн сарлаг ихтэй сум орон нутгийн иргэд хярамцагтай шөлтэй хоолонд өрөм, зөөхий хольж идэж хэрэглэсээр байна.

Эрс тэс уур амьсгалтай, өвлийн цагт -40 - 50 хэм хүйтэрдэг Монгол оронд ид хүйтний улиралд идэхэд хамгийн сайн зохицсон үндэстний уламжлалт хоол хярамцаг болон монгол дотор махан хоол мэдэхгүй хүн, хүнд хэцүү тэвдсэн цагт малынхаа цусыг ханаж хоол болгодог монгол уламжлалт зан үйлийг ойлголгүй өөрсдийнхөөрөө гаж буруу, сонин

<sup>2</sup> Хярамцаг: үхрийн цусыг гэдсэнд нь цутгаж, гүзээнд нь бөөр, зүрх зэрэг дотор эрхтний хамт хийж хөлдөөгөөд шөлтэй хоолтой хольж иддэг хөлдүү цусыг хэлнэ.

этгээд дадал зуршил хэмээн тайлбарлах нь аргагүй.

Миний эцэг ч хүүхэд ахуйдаа дайн байлдааны хүнд хэцүү цагт сарлагийн цус ханаж өл хоол залгуулдаг байсан тухайгаа үүнийг бичигч надад ярьж асныг тод санаж байна. Энэ бол нууж ичих эсвэл гайхаж мэгдэх зүйл огоот биш. Харин ч малын цусаар хооллодог зан үйлийг нарийвлан судлах ёстой гэсэн түүхч З.Лонжидтой санал нэг байна.

## ДҮГНЭЛТ

МНТ-ны зарим үг хэллэгийг монголчуудын амьдрал ахуй, ёс заншил, зан суртахууны үүднээс шинжлэн судалж дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Монголчуудын өшлийг өшиж, хяслыг хясаж “хачи” авах ёс нь тухайн цаг үе дор хэв хууль төдийгүй нийгмийн үүрэг байжээ.

2. МНТ дахь “Алалдах өдөр араны мах иднэ, Хүрэлцэх өдөр хүний мах хүнсэлнэ, тэд” гэсэн хэллэг нь монголчуудын дайн тулаантай

цаг үед шувууны махыг урьдчилан сэргийлэх эмчилгээний зориулалтаар хэрэглэдэг байсан монгол анагаах ухааны уламжлалтай холбоотой гэж үзлээ.

3. “Тэмээний цус ханаж идэх” гэсэн хэллэг нь монгол угсаатны хоол хүнсний зүйлтэй холбоотой хэллэг юм.

Эцэст нь хэлэхэд, аливаа ард түмний өнгөрсөн түүхийг тухайн үе, тухайн орчинд буйгаар нь авч үзэх ёстой. Түүнээс өнөөгийн хүн төрөлхтний нүдээр үзэж ойлгож тайлбарлах нь өрөөсгөл юм. Нөгөөтэйгүүр, улс үндэстэн бүрийн оршин буй газар орон, цаг уурын онцлогоос шалтгаалж хорхой шавьж, царцаа голиог цар цараар тавин, далай тэнгисийн амьтныг амьдаар тасчин хяргаж шарж буцалгаж идэж буй соёлт хүн төрөлхтнийг бид мушгин гуйвуулдаггүй. Харин борц иддэгийг “түүхий мах” иддэг, тарвага зурам (бозлог) агнадгийг маань оготно хулгана иддэг хэмээн бичиж буй хүмүүст бид уламжлал ёс заншлын нарийн учир, гүн ухааныг тайлбарлах нь зүйтэй гэж бодлоо.

## НОМ ЗҮЙ

- Базаррагчаа М., 1999. *Монгол үгийн гарал мөшгих нь*. УБ
- Бүрэнтөгс, 1991. *Монгол идээн товчоо*. УБ
- Владимирцов Б.Я., 2001. *Чингис хаан*. УБ
- Далай Ч., 1996. *Монголын түүх, Хамаг Монгол улс*. Тэргүүн дэвтэр, УБ
- Дашицэдэн Д., 1980. Нууц товчооны хууль цаазын зарим зүйл. - *ШУА-ийн мэдээ*, № 2, УБ
- Зориг Г., Ямаахай С., 1980. Алтайн хойлгийн аминхүчлийн судалгааны урьдчилсан дүнгээс. - *Монголын анагаах ухаан*. № 2 (34), УБ
- Карпини Плано, 1988. *Монголчуудын түүх*
- Монголын нууц товчоо*, 2009. (Сонгомол эх). УБ
- Рачневский П., 2006. *Чингис хаан, түүний амьдрал ба өв*. УБ
- Рашид-Ад-Дин, 2002. *Судрын чуулган*. 1-р боть 1-р дэвтэр УБ
- Уэтэрфорд Жак, 2012. *Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Чингис хаан*. УБ
- Цэвээнмядаг Н., 2005. Хойлогны мах идвэл элдэв шарх түргэн эдгэрдэг. <http://www.olloo.mn/modules.php?name=News&file=article&sid=8904>
- Цэрэнсодном Д., 1990. “Монголын Нууц Товчоо”-ны сийрүүлэг, тайлбар. УБ
- Чулуунбаатар Л., 2008. XIII зууны үед Монголчууд хүний мах идэж байв уу? - *Mongolica*. Vol. 21(42), УБ
- Эрэнжен хара-Даван, 2003. *Сод жанжин Чингис хаан түүний үлдээсэн өв*. УБ
- Ekvall R., 1963. A note on “Live blood” among Tibetan - Man. (дам ишлэв)
- Igor de Rachewiltz, 1972. *Index to the Secret History of the Mongols*. Bloomington
- Tannahill R., 1973. *Food in History*. L., 130 (дам ишлэв)

*SUMMARY*

*Ch. BATTULGA*

**EXPLAINING SOME EXPRESSIONS OF "THE SECRET HISTORY OF THE MONGOLS" FROM THE ETHNOLINGUISTIC ASPECT**

In this paper, the author discusses the expression *haci* (*хачу*) or *ritual for revenge* mentioned in the *Secret History of the Mongols*. He also explains the reasons why Mongolians eat human meat and drink cattle's blood, based on the factual documents. The author tries to correct the misunderstandings and inaccurate knowledge about some custom, tradition and rituals of nomadic Mongols resulting from this expression.